

Монголчууд дэлхийн бусад үндэстний нэгэн адил буурал түүхэндээ мандал буурлын аль алиныг үзэж өнгөрүүлсэн билээ. XIII зуунд Чингис хааны Монголын нэр Төв Азид төдийгүй, Европ тив цаашилбал дэлхий даяар түгэн тархаж ертөнцийг донсолгож байсан. Монголын эзэнт гүрэн задарсны дараа Монголд дотоодын хямрал үүсэж, баруун зүүн болж хуваагдан хоорондоо тэмцэж гаднын хүчинд автагдах үүдийг нээж өгсөн юм. XVII зуунд өмнө зүгээс манж нар, умар зүгээс оросууд монголчуудын оршин амьдрах орон зайг хавчин шахсанаар удам угсаа, шашин суртлаа аврах үүднээс Монголчууд Чин гүрнийг байгуулсан манжийн хаадад дагаар орсон түүхтэй. Ийнхүү Монгол орон манж-хятадын Чин гүрний нэгэн зах хязгаар нутаг болж XX зууны эхэн хүртэл 200 гаруй жил түүхэн их үйл явдлаас зайдуу алс бөглүү байсан юм.

XX зууны эхээр манж нарын байгуулсан хятадын Чин гүрэн задарч нурсан явдал монголчуудын хэдэн зуун жил алдагдсан төр улсаа мандуулах үндэсний ухамсрыг сэргээв. Халх Монголын шарын шашны тэргүүн VIII Богд Жибзундамба хутагт энэхүү тэмцлийг толгойлсон нь санамсаргүй зүйл биш. Бүх монголчуудыг үндэсний төр улсаа сэргээх нэгэн их зорилгод нэгтгэн зангидаж чадах цорын ганц хүч нь шарын шашны тэргүүн байсан юм. Чин гүрнээс бүрмөсөн ангижирч Хятадаас тусгаар болохын тулд умард хөрш болох хаант Оросын дэмжлэг зайлшгүй хэрэгтэйг тэр үеийн Монголын эрх баригчид сайтар ойлгож байлаа. Хаант Орос ч Хятадтай олон мянган км хиллэх Монголыг завсрын бүс хэлбэртэй өөрийн нөлөөнд байлгахыг эрмэлзэж байв. Хэдий тийм ч Японтой 1907, 1910, 1912 онд удаа дараа нөлөөнийхөө хүрээг хуваах тухай нууц гэрээ байгуулсан хаант Орос 1911 онд зарлагдсан Монголын тусгаар тогтнолыг бүрэн дэмжихээс татгалзаж Монголыг автономит хэлбэртэй байлгахгаар 1915 онд Хятадтай ярьж тохирсон юм. 1917 онд хаант Орост төр хямарсныг ашиглан Хятадын засгийн газар 1919 онд Хүрээнд цэрэг ирүүлэн Монголын автономийг хүчээр эвдэж цуцалсан билээ.

1919-1921 он Монголын хувьд цаг төрийн үймээнтэй жилүүд байлаа. Эхлээд хятад цэргүүд эзэгнэн байснаа Орос оронд гарсан Октябрийн хувьсгалаас дүрвэн дайжсан цагаантны цэргүүд Монголд цөмрөн орж их Хүрээг түр эзлэв. Энэ үеэр Монголын автономнийг дахин сэргээж, Богд гэгээнийг хаан ширээнд дахин залах зорилготой үндэсний үзэлтэй хэсэг монголчууд нэгдэн энэ зорилгоо биелүүлэхийн тулд умард хөрш Орос оронд тогтоод байсан большевик засгийн газраас тусламж эрэхээр одов. Оросын большевикууд хэдийгээр Хятадтай харилцаа хурцдахаас эмээж байсан боловч Монголын газар нутгийг өөрсдийн эсрэг түшиц газар болгон цагаантны хүчинд ашиглуулахгүй гэсэн үүднээс Монголын үндэсний үзэлтнүүдийг улс төрийн нам болгон зохион байгуулах, цэрэг элсүүлэн бэлтгэхэд зэр зэвсэг бүх талын туслалцаа үзүүлж, Улаан армийн зарим анги, Сибирийн партизаны ангийг Монголд оруулан өөрсдийн хүссэн засгийн газрыг байгуулж чаджээ. Монголд томилогдон очсон Оросын большевикууд үзэл бодол таарахгүй

\*Ц. Батбаяр-ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал, дэд эрдэмтэн

монголчуудыг шууд устгах замаар хувьсгалт үзлийг монголын удирдагчдад нялзаан 1924 он гэхэд «Монголд хөрөнгөтний бус» хөгжлийн зам буюу нүүдлийн мал аж ахуй зонхилсон Азийн оронд коммунизм байгуулах Лениний туршилтыг хэрэгжүүлэх номлолоо хүчээр тулгасан байна. Энэхүү Монголд коммунизм байгуулах туршилт үндсэндээ 70 орчим жил үргэлжилсэн юм. Энэ түүхийг 1930-аад оны дундаас 1952 он хүртэл төр барьсан Чойбалсангийн үе, 1952-оос 1984 он хүртэл төрийн эрхийг барьсан Цэдэнбалын үе гэж ангилж болно. Чойбалсангийн үед хийгдсэн хамгийн эмгэнэлт явдал бол монголчуудын олон зуун жилийн турш бүтээсэн соёлын өв хэдэн зуун сүм хийдийг эвдлэн устгаж, олон арван мянган лам хувраг, ард иргэдийг хэлмэгдүүлсэн явдал юм. Энэ зорилгодоо большевикууд «дотоодын ангийн тэмцлийн онол» гэдгээ ашигласнаас гадна 30-аад онд Азийн эх газар, Хятадад түрэмгийлж байсан Японы аюулыг Монголд тохоон авчран хэт хөөрөгдөж Монголд Японтой сүлбэлдэхэд бэлэн «тавдугаар цуваа» байгаа мэтээр лам нар, энгийн иргэдийг олноор нь устгах аян шалтаг болгосон билээ.

1939 оны V-IX сард Монголын дорнод хил Халх голын орчим нэг талаас зөвлөлт-монгол, нөгөө талаас япон-манжгогийн цэргийн хооронд болсон зэвсэгт мөргөлдөөн (Японд Номонханы хэрэг явдал гэж нэрлэдэг) «Японы аюул» гэгчийг бодитой болгон батлан харуулах гэсэн тэр үеийн ЗХУ-ын удирдлагын төлөвлөгөөнд бүрэн нийцсэн юм. Энэ ч үүднээс ЗХУ 1945 оны VIII сард Японы эсрэг дайнд холбоотнуудын талд нэгдэн оролцохдоо Монголын морин армийг татан оролцуулсан билээ.

Энэ бүгдийг үл харгалзан Чойбалсангийн үед Монголын төр ёсны уламжлал, монгол үндэс угсаагаа гэсэн язгуур чанар алдагдаагүй үлдсэнийг хэлэх хэрэгтэй. Үүнд марксист-ленинист үзлийг хүлээн авах монголын хөрс суурь нимгэн байсан, түүнчлэн 30-аад оны Монголын удирдагчид Гэндэн, Амарын байр суурь, түүнчлэн Чойбалсангийн өөрийнх нь хувийн үзэл бодол ч нөлөөлсөн нь гарцаагүй.

Монголчуудын ахуй амьдрал, зан заншил, ёс суртахууныг социалист агуулгатай болгон нэг хэвээр цутгах гэсэн оролдлого Цэдэнбалын үед хүчтэй явагдсан гэж хэлж болно. Дэлхийн II дайны дараа ЗХУ нь Зүүн Европ болон Азийн хэд хэдэн оронд коммунист намыг дэмжин засгийн эрхэнд гаргаж социалист лагерь гэгчийг байгуулж чадсан билээ. Монгол ч энэхүү социалист лагерьт багтах болсноор тэдэнтэй нэгэн ижил улсын өмчид тулгуурласан төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг бий болгох, бүгдийг тэгшитгэн хуваарилах зарчим баримталж нэг л үзэл суртлаас бусдыг үл зөвшөөрөх байдалд шилжсэн билээ. Ялангуяа 70-аад оны сүүлээр Ю. Цэдэнбал Зөвлөлт болон социалист бусад оронтой «бүх талаар ойртон нягтрах» лоозонг дэвшүүлж монголчуудын үндэс угсаагаа гэх үзлийг устган нэг ижил сэтгэдэг нэг хэвээр цутгасан мэт болгохыг чармайн оролдсон юм.

Монголын гадаад харилцаа өргөжиж Монгол улс 1961 онд НҮБ-д элссэн боловч Монголын гадаад бодлого үндэсний эрх ашгаа бус социализмын эрх ашиг хэмээгчийг дээдлэн зөвхөн ЭЗХТЗ-ийн орнуудтай харьцах туйлын өрөөсгөл байдалтай байв. 1949 онд БНХАУ байгуулагдсаныг дагалдан Монгол улс 1950-аад онд нэг хэсэг үе Хятад, Зөвлөлт аль алинтай нөхөрсгөөр хамтран ажиллах ховорхон боломж олж авсан юм. Гэвч 60-аад онд Хятад-Зөвлөлтийн хооронд эхэлсэн үзэл суртлын маргаан төрийн хоорондох дайсагнал болж хувирахад Монголын удирдагчид ЗХУ-ын талыг зуун хувь баримтлан бүрэн дагасан билээ. Ийнхүү 30-аад онд «Японы аюул» гэж байсантай адил 60, 70-аад онд «Хятадын аюул» бий болж Зөвлөлтийн цэрэг Монголд 1920-иод, 30-аад оны дараа 3 дахь удаагаа 60-аад оны сүүлээр орж

ирж байрлан Монгол нь үндсэндээ Хятадын эсрэг ЗХУ-ын стратегийн нэгэн чухал район болж хувирсан юм. Зөвлөлтийн цэрэг Монголд байрлаж байсан явдалд БНХАУ-ын удирдагчид туйлын эмзэглэж байсан бөгөөд 80-аад онд тэд Зөвлөлттэй харилцаагаа хэвийн болгох гурван урьдчилсан нөхцөл тавихдаа үүнийг нэг нөхцөлөө болгосон нь санамсаргүй зүйл биш ээ.

1985 оноос М. С. Горбачевын ЗХУ-д хэрэгжүүлж эхэлсэн «перестройка» Монголд мөн шууд нөлөөлсөн юм. 1984 онд Цэдэнбалыг Москвад «эмчлэхээр» авч явсаны дараа Ж.Батмөнх 1989 он хүртэл Монголын нам, төрийн эрхийг барьсан юм. Ж. Батмөнх хэдийгээр ноён нуруу алдаагүй боловч Монголд ардчилал, зах зээлд шилжих эрс өөрчлөлт хийхийг зориглоогүй, үйл явдлыг аялдан дагасан хэвээр байв. Түүний үеийг Дэн Сяопины өмнөх, 1976 оны дараах Хуа Гофэний богино үетэй зарим талаар адилтгаж болох юм. Гэвч Монголд өөрийн Дэн Сяопин байгаагүй бөгөөд цоо шинэ үе л санаачилгыг гартаа авахгүй бол олон жил хөлдсөн мөсөн хунгарыг хайлуулах аргагүй байв.

ЗХУ-ын перестройка, Зүүн Европын ардчиллын ялалтад зоригжсон Монголын шинэ үеийнхэн 1989 оны сүүл, 1990 оны хавар хэд хэдэн шийдэмгий тэмцлийн арга хэмжээ хэрэгжүүлж төрийн бүх эрхийг захирч байсан МАХН-ын Улс төрийн Товчоог огцруулж, 1990 оны VII сард Монголд анх удаа чөлөөт сонгууль хийлгэж чадсан билээ. Энэ сонгуулийн дүнд байгуулагдсан эвслийн засгийн газар 1990-1992 оны 2 жил орчмын хооронд, Монгол орныг зах зээлийн эдийн засгийн замд гаргах оролдлогыг туйлын хүнд нөхцөлд хийв. Цай, тамхи, даавуу даалимбаас эхлээд бензин шатахуун, сэлбэг хэрэгсэл зэрэг бараг бүх импортыг хангаж байсан ЗХУ өөрөө хямарч, эцэстээ задарч эдийн засгийн хэвийн харилцаа алдагдсан явдал Монголд нэн хүндээр тусав. АНУ, Япон зэрэг хөгжилтэй орнуудтай харилцаа тогтоон зээл туслалцаа авахад зохих цаг хугацаа хэрэгтэй байлаа. Хэдий тийм ч энэ 2 жилийн хугацаанд Д. Бямбасүрэнгийн засгийн газар олон улсын санхүүгийн байгууллагууд, дэлхийн зонхилох донор орнуудын итгэлийг олж холбоо тогтоон Монголыг дэмжигч орнуудын бүлгийг бий болгож Токиод хоёр ч удаа хандивлагч орнуудын зөвлөлгөөнд оролцож 1992 оны 2 дугаар хагасаас эхлэн дараагийн 18 сард 320 сая ам. долларын зээл болон буцалтгүй тусламж үзүүлэх амлалт гаргуулав.

Эдийн засагт чөлөөт үнийн тогтолцоо бүрдүүлэх, төвлөрсөн улсын өмчийг задлан хувьд шилжүүлэх талаар хийсэн Д. Бямбасүрэнгийн засгийн газрын алхмууд зөрчилтэй байсан хэдий ч зайлшгүй байсан юм. Эдгээр алхмыг цааш тууштай үргэлжлүүлэн эцсийн үр дүнд хүргэж чадах эсэх нь энэ 1992 оны VI сарын сонгуульд ялж МАХН-ын дангаар байгуулсан П. Жасрайн шинэ засгийн газрын үйл ажиллагаанаас ихээхэн хамаарна.

Өнгөрсөн хоёр жилд Монголын гадаад харилцаанд эргэлтийн шинж чанартай өрчлөлт гарч Монгол улс анх удаа дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн хэмээн өөрийгөө ухаарч ажиллах болов. Гадаад бодлогодоо үндэсний эрх ашгийг дээдлэх болж харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх прагматик хандлагыг голлох болов. Ялангуяа өмнө нь огт харьцдаггүй шахам байсан Өрнөдийн хэмээгдэх орнуудтай. Мөн Азийн орнуудтай харилцаагаа идэвхжүүлэв. Өмнөд хөрш БНХАУ-тай төрийн дээд хэмжээнд харилцан айлчлалт хийж хоёр орны худалдаа, хүн солилцоо түргэн өсөж байна. Өөрөөр хэлбэл, түүхийн өмнөх сургамжаас дүгнэлт хийж түүхээс заяасан хоёр хөрштэйгээ харьцахдаа аль нэгтэй нь хэт ойртон нөгөө хөршдөө дайсагнах байдлыг дахин давтахгүй, аль алинтай нь сайн хөршийн ёсоор харьцах бодлого баримталж байна. Мөн АНУ, Япон, Европын хамтын нийгэмлэгийн орнууд зэрэг хөгжилтэй орнуудтай тогтоосон харилцааг улам

бэхжүүлж аль болох олон орны хөрөнгө оруулах таатай нөхцөлийг бүрдүүлэх, гадаад худалдааны түнш нарыг зохистой хэмжээнд аль болох олон байлгах нь Монголын гадаад бодлогын нэгэн чухал зорилго болно.

1990-ээд оныг 1910-аад онтой ямар нэг талаар зүйрлэж болно. 1910-аад онд өмнөд хөрш Хятадад Чин гүрэн задарч монголчууд олон зуун жил алдагдсан төр улсаа түр ч гэсэн сэргээж чадсан билээ. 1990-ээд онд умард хөрш Орост ЗХУ задарч Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн баттай болж чадлаа. Түүхээс заяасан энэхүү ховорхон бололцоог бүрэн дүүрэн ашиглаж хүн төрөлхтний сонгож авсан ардчилал, зах зээлийн зам дээр баттай зогсож чадах эсэхээс Монголын цаашдын хувь заяа шалтгаалах нь дамжиггүй.